



**БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2025 оны 08 сарын 18 өдөр

Дугаар A/171

Улаанбаатар хот

**Үхрийн арьс товруутах өвчнөөс урьдчилан
сэргийлэх яаралтай дархлаажуулалт
зохион байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 9.4, 9.6 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтын 2.1.1 дэх заалт, Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2025 оны A/240 дүгээр тушаал, Нийслэлийн Засаг даргын 2025 оны A/1079 дүгээр захирамж, Нийслэлийн мал эмнэлгийн газрын даргын A/71 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дүүргийн нутаг дэвсгэрт үхрийн арьс товруутах өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтыг 2025 оны 08 дугаар сарын 04-ний өдрөөс эхлэн 14 хоногийн хугацаанд шуурхай зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг Мал эмнэлгийн тасаг (Д.Шүрэн-Эрдэнэ)-т үүрэг болгосугай.

2. Үхрийн арьс товруутах өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад тус дүүргийн өвчинд мэдрэмтгий 1000 тугал, 3400 үхрийг бүрэн хамруулж ажиллахыг Мал эмнэлгийн үйлчилгээний нэгж "ЦЭФ трейд" ХХК (А.Цэрэндагва)-д, дархлаажуулалт хийгдэх товлосон хугацаанд малчдад зар хүргэж, мал, амьтнаа бэлэн байлгах ажлыг зохион байгуулж ажиллахыг хороодын Засаг дарга (Н.Нямзав, Б.Батзориг) нарт тус тус үүрэг болгосугай.

3. Үхрийн арьс товруутах өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад шаардагдах төсвийг хавсралтаар баталж, 2,076,300 (хоёр сая далан зургаан мянга гурван зуу) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын Ерөнхий нягтлан бодогч (С.Баасанхүү)-д зөвшөөрсүгэй.

4. Заавар зөвлөмж өгч, мэргэжил арга зүйн болон нэгдсэн удирдлагаар ханган, санхүүгийн тайланг үйл ажиллагаа зохион байгуулж дууссанаас хойш ажлын 5 хоногийн дотор ирүүлэхийг Мал эмнэлгийн тасаг (Д.Шүрэн-Эрдэнэ)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2025 оны 02 сарын 18-ны өдрийн
А/А/ захирамжийн хавсралт



ҮХРИЙН АРЬС ТОВРУУТАХ ӨВЧНӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ
ВАКЦИНЖУУЛАЛТ БОЛОН ХЯНАЛТЫН АЖИЛД
ШААРДАГДАХ ЗАРДЛЫН ТӨСӨВ

1. Шатахуун, зүү тариур, халдвар хамгаалал, холбоо, зарлан мэдээллийн зардал

№	Зардлын төрөл	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ	Нийт
1	Шатахуун А-92	л	200	2590	518,000
2	Тариур	ш	500	400	200,000
3	Зүү	ш	500	700	350,000
4	Нэг удаагийн маск	ш	200	200	40,000
5	Нэг удаагийн малгай	ш	200	200	40,000
6	Нэг удаагийн бээлий	Хайрцаг	1	35000	35,000
7	Цэнхэр спирт	л	2	6000	12,000
8	Шатахуун А-92 /вакцины татан авалт болон вакцинжуулалтын ажлын гүйцэтгэлийн үеийн хяналт шалгалтад/	л	70	2590	181,300
ДҮН					1,376,300

2. Ажиллах хүчний зардал

№	Ажиллах хүч	Тоо	Нэг өдрийн цалин	Нэг өдрийн нийт цалин	Ажиллах хоног	Нийт ажлын хөлс
1	Туслах ажилтан	2	50000	100000	7	700,000
ДҮН						700,000
НИЙТ ДҮН						2,076,300